

Манмин Мэдээ

Дугаар 21 2012 оны Дөрөвдүгээр сарын 1

«Ариун Сайн мэдээнд тэмүүлэн Солонгос хүртэл ирсэн билээ.»

Гадаадын 10 улс орноос ирж оролцсон ММБТ-н олон улсын бэлтгэл хөтөлбөрийн нээлт



«Ариун сайн мэдээ бол зүрх сэтгэлийн гэмийг хүртэл уг үндсээр нь хаяж, өөрчлөгдөн төгс сүнсний түвшинд хүртэл хөтөлж өгдөг сургаал билээ. Миний сүнс сэтгэл, миний гэр бүл, миний ард түмэн, өөрийн улс үндэстнээ ариун сайн мэдээгээр сэрээн, Шинэ Иерусалим хүртэл замчилсан сүнсэлэг дайчин болохыг хүсэж байна.» Өнгөрөгч 2-р сарын 3-н өдөр ММБТ (Манмин миссионер бэлтгэх төв)-н олон улсын бэлтгэл хөтөлбөрийн нээлтийн цуглааны үйл ажиллагаанаар тус төвийн захирал И Жи ёон пастор дээрх үгийг айлдсан билээ.

Үүний дараа Америк, Израйль, Орос, Испани, Хятад, Тайван, Вьетнам, Казакстан, Непаль Индонези зэрэг гадаадын 10 улсаас хүрэлцэн ирж оролцож буй 40 н сонсогчид бие бие рүүгээ харан хамтдаа «Манмин» хэмээн нэгэн дуугаар хашгирч байв.

Сүм байгуулагдахаас эхлэн дэлхийн дахинаа сайн мэдээ тараах алсын зөн харааг авч, эрчимтэй үйл ажиллагааг явуулсаар ирсэн манай сүм нь үүний нэгэн хэсэг болох сайн мэдээ тараах мэргэжлийн ажилтанг бэлтгэх төв болох ММБТ-г байгуулан дэлхий даяар газар болгонд сайн мэдээ тунхаглагчдыг илгээсэн билээ. Энэ удаад эхэлсэн гадаад хүмүүст зориулсан олон улсын бэлтгэл хөтөлбөр нь Доктор И Жей руг пасторын айлдсан сүнс зүгийн

сургаалыг дэлхий хэмжээнд зэвсэглэн суралцан, Манмин төв сүмийн бүтэц, дотоод зохион байгуулалт, сүмийн бүх төрлийн үйл ажиллагааны арга барилыг сурахыг хүсэж буй гадаад дахь салбар сүм чуулганы номлогчид ба ажилтан хүмүүсийн тасралтгүй хүсэлтийн үр дүнд эхэлсэн билээ.

Энэ нь 10,000 гаруй салбар



ММБТ-н олон улсын бэлтгэл хөтөлбөрт оролцож буй сонсогч нар лекц сонсож байгаа нь 1сарын сургалтын хугацаанд илүү ихийг сурч, Бурханы жинхэнэ ажилтнуудаар бэлтгэгдэн гарахыг эрмэлзэж буй тэд. (байрлал: Шинээр ирэгсдийг хүлээн авах танхим, аман орчуулга: Англи хэл, хятад хэл)

ба хамтарсан сүмүүдтэйгээ хамт дэлхий дахиныг Ариун сайн мэдээгээр нэгтгэхэд түлхэц болохуйц гүн утга учир, чухал ач холбогдол бүхий үйл явдал юм. Энэхүү хөтөлбөр сургалтанд хамрагдагч нар Хоёрдугаар сарын 27 хүртэл номлогчдын байранд байрлан өглөөний 10 цагаас оройн 18 цаг (Даваа гаригт оройн 22 цаг хүртэл ба

Бямба гаригт өдрийн 15 цагаас оройн 22 цаг) хүртэл лекц сонсогчид бүрийн мөргөл ба оройн Даниел залбирлын цагт хамрагдах гэх мэт маш нарийн шахуу төлөвлөгөөний дагуу оролцон бэлтгэгдэх хэрэгтэй байлаа.

Пасторуудын ахлагч И Сү жин пастор болон 20-д сургаал айлдагч нар Ариун сүнсний



Кипр бүгд найрамдах улсад MIS(Манмины олон улсын библийн сургууль)-н лекц эхлэв.

Өнгөрсөн нэгдүгээр сарын 27-нд Газар дундын тэнгисийн зүүн хэсгийн арлын улс Киприйн бүгд найрамдах улсын нийслэл хот болох Никосиад Манмин олон улсын библийн сургуулийн сургалтын үйл ажиллагаа эхэлж Беренд Хен Розенпастор (Израйль Тел Авив Ливинстон Сүм) удирдлагатайгаар нээгдэв.

Сургалт сард 1 удаа нэг 7 хоногын турш «Загалмайн Үг» сургаалын дагуу англи хэл дээр явагддаг ба хамт үүний хамт орос болон болгар хэл дээр хамт орчуулагдаж байна. Сурагчид хичээлгүй үедээ сурах бичиг уншиж бие даан хичээллэж, багштайгаа e-мэйл болон мессэнжэрээр холбогдон видео хичээл хийдэг билээ. Сургагч багш Розен пастор хэлэхдээ «Сургалтын үед сурагчид нулимс дуслуулан байж талархаж Бурханаас мэдүүлж өгч буй сүнсний гүн утга бүхий сургаалыг биширч байгаагаа илэрхийлдэг» гэж хэлсэн билээ.

бялхам залбирал, Загалмайн үг, IКоринт номын тайлбар, Левит номын тайлбар, Тэнгэрлэг хүч ба сайн мэдээ, Ариун байдал ба эрх мэдэлт хүч, Сүмийн сэргэлтийн нууц, 7-н чуулган, Мөргөл ба айл эргэх аргачлал, Сайн мэдээ тунхаглагчийн хувийн зохион байгуулалт, олон улсын ёс зүй, харилцах урлаг, Санхүүгийн менежмент, Сайн мэдээ тараах тактик зэрэг сэдвүүдээр хөтөлбөрт сургалтанд хамрагдаглаа.

Мөн үүнээс гадна Доктор И Жей руг пасторын сургаалын товчлол хийх, сургаал заах бэлтгэл, библи унших, библийн ишлэл цэжлэн шалгуулах зэрэг хөтөлбөрт хамрагдана. Мөн GCN телевиз болон, сүмийн төрөл бүрийн хэлтэс албадын газарт зочилж, Солонгос үндэсний ёс заншлын тухай болон хотоор аялсан юм. Хоёрдугаар сарын 23-нд, тэд Муан амтат усны хүрээлэнд зочлон гадаах хүлээн авалтанд оролцсон билээ.

Испаниас ирсэн Хенри Пол пастор (Барселон Алфори Манмин Сүм) «энэхүү хөтөлбөрт хамрагдахын тулд сүмийнхээ ажилтнуудтай хамт залбирлаар бэлдсэн билээ. Сургалтаар дамжуулан олон зүйлийг сурч, Бурханы хүн Доктор И Жей руг пасторын сайн мэдээ тараах ажлын тухай илүү ихийг сурахыг хүсч, сүнсээр өссөн нандин цаг байхыг хүсч байна» гэж өгүүлсэн юм.

Мөн Надин Миямба итгэгч (Нью Йорк Олон улсын Манмин Сүм), Доктор И Жей руг пасторын бичсэн номоор дамжуулан олон зүйлийг ухаарч, 2006 онд Медисон скьюарт гаденд болсон Доктор И Жей руг пасторыг урьсан Нью Йоркын нэгдсэн их цуглаанаас их ивээл хүртсэн билээ. Доктор И Жей руг пасторын телевизээр айлдсан сургаалыг сонсоод солонгост очиж үзмээр санагдсан. Тиймээс энд заагдах сургаалиудыг гэр бүл ба бүх хамаатнууддаа дамжуулахыг хүсэж байна. Энэ удаагын сургаалтаар дамжуулан их зүйлийг сурна гэж найдаж байна.

«Загалмайн Үг» цувралаас -(19)

Есүсийн загалмайн дээр айлдсан эцсийн долоон үг (3)

«Есдүгээр цагийн орчим Есүс чанга дуугаар-Ели, Ели, лама сабахтани? гэж хашхирлаа.

Энэ нь 'Бурхан минь, Бурхан минь, юунд Та Намайг орхив?' гэсэн үг аж.» (Матай 27: 46)

«Үүний дараа Есүс бүх юм эдүгээ гүйцэлдсэнийг мэдээд Судар биелэгдэхийн тулд-Би цангаж байна гэлээ.

Дүүрэн цагаан цуутай сав тэнд байжээ. Тэд цуу шингээсэн далайн хөвөнг хиссопын мөчирт торгоож Есүсийн аманд хүргэв.

Есүс цууг амсаж-Гүйцэлдлээ! гээд, тэргүүнээ гудайлган сүнсээ даатгав.» (Иохан 19: 28-30).

Ихэнхи хүмүүс үхэх нь ойртоод үедээ өөрийн амьдралаа эргэн харж гэр бүл болон ойр дотныхондоо гэрээслэл болгон захиас үгээ үлдээдэг. Үүний нэгэн адил хүн төрөлхтөнийг аврахаар ирсэн Есүс загалмайн дээр цовдлогдон амьсгал хураахын өмнө хэдэн үг айлдсан байдаг ба түүнийг нь «Загалмайн дээр айлдсан эцсийн долоон үгс» хэмээн нэрлэдэг билээ.

Бурханы Хүүгийн хувьд хүн төрөлхтөний аврах төлөвлөгөөг төгс гүйцэтгэсэн Есүсийн эцсийн долоон үгсээр дамжуулан Эзэний зүрх сэтгэлийг гүнээ ухаарснаараа Бурханы жинхэнэ үр хүүхэд болох билээ. Манмин Сүмийн мэдээнд дурдагдсан зүйлсийн дагуу Есүсийн загалмайн дээр айлдсан дөрөв, тав болон зургаа дахь үгнүүдийн талаар тайлбарлая.

Дөрөвдэх үг нь: «Ели ели лама сабахтани»

Есүс «Ели ели лама сабахтани» хэмээн Матай 27:46-д айлдсан ба орчуулбал, «Бурхан минь Бурхан минь юунд Та намайг орхив?» гэсэн утгатай билээ Энэ нь Есүс Бурханд гомдоллох ба загалмай дээрх зовлонгоос болж гоморхон ялархаж байгаа байдал огтхон ч биш билээ.

Есүс энэ газар дээр ирэхээс ч өмнө өнө эртнээс загалмайн зовлонг эдлэх тухай мэдэж байсан бөгөөд Бурханы хүсэл төлөвлөгөөг биелүүлэхийн тулд загалмайн замыг сонгосон учраас Бурханд гомдоллох шаардлагагүй билээ. Энэ үгэнд сүнс зүгийн чухал гүнзгий утга агуулагдаж байгаа билээ.

Эхлээд «Есүс чанга дуугаар» нь гэдэг талаар тайлбарлая. Есүс загалмайд цовдлогдохын өмнөх орой шөнөжингөө ийш тийш чирэгдэн олон газар аваачигдан шүүгдэж, маш олон удаа аймшигтай хэрцгийгээр ташуурдуулсан ба загалмайд цовдлогдон 6 цагын турш цусаа урсган модонд өлгөгдсөн билээ. (Марк 15:25). Тиймээс Түүнд чанга дуугаар хашхирах хэмжээний тамир тэнхээ байхын аргагүй байдалтай байсан ч бүх хүчээ шавхан үгээ айлдаж байгаа нь бүх хүмүүс энэ үгийг сонсоод «Яагаад Есүс Бурханд хаягдсан мэт болов?» «Ямар учраас юуны төлөө аймшигтай загалмайд цовдлогдох болов?» гэдгийг ухааруулахыг хүссэн учраас билээ.

Тухайн үед Есүс харагдсан загалмайд дээр цовдлогдох хүртэл Бурханаас үнэхээр хаягдсан мэт байлаа. Энэ нь бүхий л хүн төрөлхтөний гэм нүглүүдийг уучлан тэнгэрийн орон руу аваачих төлөө билээ. Энэ дэлхий дээрх бүх хүмүүс хуулийн хараалийн улмаас Бурханд гологдон хаягдан үхдэг шиг Есүс бидний өмнөөс тэр хараалийн авч, тэр хараалийн улмаас Бурханд хаягдсан юм. Тийм учраас энэ зүйлийг бүх хүмүүст ухааруулахын тулд Есүс бүх чадлаа шавхан байж, хашгиран айлдсан билээ.

Библи дээр үзвэл Есүс Бурханыг дуудах үедээ үргэлж маш дотноор «Аваа, Хайрт Аваа» хэмээн дуудаг байсан билээ. Гэтэл өнөөдөр сургаалын библийн үг болох Матай 27:46-д, Есүс «Бурхан минь»



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

хэмээн дуудаж байсны учир нь хараал хүргэж загалмайд цовдлогдсон гэмтний нэгэн адил болсон тул Тэрээр Ариухан Бурханыг дураараа «Аваа» гэж дуудаж зүрхлээгүй юм. Үүнтэй адил, та бүхэн хэдийгээр Эзэнд итгэдэг гэсэн мөртлөө Бурханы хүслийн дагуу амьдралгүй Бурханыг эсэргүүцэгч дайсан сатан, атгаг муу сүнснүүдийн уруу татлагаад автан амьдармагцаа яаж Бурханы хүүхэд мэт нүүр бардам Бурханыг «Аваа» гэж дуудах билээ. Тэгэх боломжгүй билээ.

Мөн түүнчлэн Бурхан гэм нүгэлтнүүдийн төлөө цорын ганц Хүүгээ зориулсан хэдий ч үй олон хүмүүс урьдын хэвээрээ үүнийг ойлголгүй дэлхий ертөнцтэй хутгалдан, самуурч үхлийн замаар явсаар л байгаа билээ. Бүхий л хүмүүсийг Есүс яагаад загалмайд цовдлогдсний утга учрыг ойлгож, Түүнийг Аврагч Эзэнээр хүлээн зөвшөөрч мөнх амийг өгөхийг хүсэн чанга дуугаар «Ели ели лама сабахтани» гэж хашгирсан билээ.

Тиймээс Есүс бидний гэм нүглийн улмаас хараагдан хаягдаж, загалмайд цовдлогдон нас барсныг сэтгэл зүрхнийхээ угаас итгэдэг бол одоо үүнээс илүү гэм нүгэлд хутгалдалгүй, гэм нүглээс хол ариунаар амьдарснаар Бурханыг чин сэтгэлээсээ «Аваа» гэж дуудах үр хүүхдүүд нь болох хэрэгтэй билээ. Мөн Загалмай үгийг идэвхитэй тараан үнэнийг мэдэхгүй үхэл рүү явж буй хүмүүсийг авралыг зам руу удирдах хэрэгтэй билээ.

Тав дахь үг нь: «Би цангаж байна.»

Иохан 19:28-д үзвэл хуучин гэрээний зөгнөлүүд биелэгдэхийн тулд Есүс «Би цангаж байна» хэмээн айлдсан байдаг харж болох билээ. Хүн их хэмжээний цус алдах тохиолдолд ам хатаж, их цангах байдал ордог. Ялангуяа Есүс нь Израйлийн хуурай ширүүн уур амьсгалтай нөхцөлд удаан хугацааны турш халуун нарны доор загалмайд цовдлогдон өлгөөтэй байдалд ямар их ам хатаж цангасан бол оо?

Гэсэн хэдий ч Есүс зүгээр нэг махан биеийн цангааг тайлах гэж «Би цангаж байна» гэж айлдсан бус үүнд мөн сүнс зүгийн утга агуулагдсан байгаа юм. Энэ нь Есүс Өөрийнхөө цусны үнийг буцааж олж авахын тулд ба үүгээрээ цангааг минь

тайлж өгнө үү! гэж захисан сүнс зүгийн утгатай үг билээ.

Тэгвэл, бид яаж «Есүсийн цусны үнийг буцааж өргөн барих вэ?» Есүс цусаа ургасны гол утга учир нь гэм нүгэлт хүн төрөлхтөн аврахын тулд байсан бөгөөд «Есүсийн цусны үнийг буцааж өргөн барих» гэдэг нь там руу явж буй хүмүүсийг идэвхитэйгээр сайн мэдээ тараан тэнгэрийн орон руу удирдахыг хэлж байгаа билээ. Шууд сайн мэдээ тараах болон үүнээс гадна хүмүүсийн авралын төлөө залбирах, сайн мэдээ тараах үйлсэд өргөл өргөн дэмжих, зэрэг төрөл бүрийн аргаар хүмүүсийг аврах боломжтой билээ.

Мөн Есүс, «Би цангаж байна» хэмээн айлдахад нэгэн хүн цуу шингээсэн далайн хөвөнг хиссопын мөчирт торгоогоод аманд хүргэсэн билээ. Энэ үед аманд хүргэсэн цуу нь цангааг тайлсан бус хуучин гэрээнд зөгнөсөнчлөн (Дуулал 69:21) цууны амтыг амсах ёстой байсан сүнс зүгийн утга агуулагдсан билээ.

Есүс гашуун цууг амсдаг нь Есүс гашуун гай зовлонг Өөртөө авч бидэнд шинэ цууг амсуулахын тулд билээ. Удаан хугацааны турш хадгалагдсан гашуун цуу нь хуучин гэрээний хатуу хуулийг хэлж байгаа бол, шинэ цуу нь Есүсээр дамжуулан төгс болсон шинэ гэрээний хайр энэрэлийн хууль гэсэн утгатай юм.

Хуучин Гэрээний хуулийн дагуу бүх гэм нүгэлтнүүд хийсэн хэргийнхээ шийтгэлийг заавал хүртдэг ба уучлагдахыг хүсвэл хэдэн удаа амьд амьгнаар цуст тахил өргөх ёстой байв. Гэтэл Есүс Өөрөө гэм нүглийн төлөөх цуст тахил болж загалмай дээр нас барсанчлан хуулийн бүх л хараалаас чөлөөлж, бидний төлөө гашуун цууг авсан билээ.

Тиймд бид Есүс Христэд итгэн чин сэтгэлээсээ өөрийн бүх гэм нүглээ гэмшвэл уучлагдах боломжтой ба энэ нь шинэ цууг амсаж буй хэрэг билээ. Есүс энэ үнэнийг мэдүүлэхийн тулд «Би цангаж байна» хэмээн айлдаж гашуун цууг амссан билээ.

Зургаа дахь үг: «Гүйцэлдлээ!»

Иохан 19:30-д, «Есүс цууг амсаж-Гүйцэлдлээ! гээд тэргүүнээ гудайлган сүнсээ даатгав» хэмээн айлдсан байдаг

ба энэ «Гүйцэлдлээ!» гэдэг нь хүн төрөлхтөнийг аврах үйл ажиллагаа бүгд бүрэн гүйцэд болж хайраар хуулийг төгс болголоо гэсэн үг юм.

Хуульд үзвэл «Нүглийн хөлс бол үхэл» хэмээснээр бүх гэм нүгэлтнүүд үхлийн шийтгэлийг авч там руу явах ёстой юм. Мөн Бурханы ард түмэн нь гэм нүглээсээ уучлагдахын тулд хэд хэдэн удаа үхэр болон хонийг барьж авчраад цуст тахил өргөдөг өргөх ёстой боловч Есүс загалмай дээр цовдлогдон нас барснаар бүхий л хуулийн хараалаас чөлөөлсөн юм. (Еврей 7:27)

Есүсийн ингэж Өөрийгөө зориулах үйл явц нь хүний төсөөлөхийн ч аргагүй асар их хайрын хүчээр бий болсон зүйл билээ. Эрхэм төгс хүчит Бурханы Хүү энэ газарт ирээд сул дорой өрөвдөлтэй хүн төрөлхтөнд тэнгэрийн орны сайн мэдээг зааж өгч, бүхий л өвчин ба сул дорой байдлыг эдгээж, засаж өгсөн билээ. Тэгээд гэм нүгэлтнүүдийн гарт баригдан ташуурдуулан өргөст титмийг зүүж, гар ба хөлөө хадуулан бүх өвдөлт зовлонг туулан гарсан билээ.

Энэ мэт асар их хайр ба золиосоор дамжуулан хүн төрөлхтөнийг удирдаж буй дайсан сатан, муу ёрын сүнснүүдийн үхлийн эрх мэдлийг бяцлан хаяж, Есүс Христэд итгэх итгэлээр мөнх амийг авч, тэнгэрийн орон руу орох боломжтой болсон тул бид одоо яах хэрэгтэй билээ? Есүс Бурхан Аавын хүсэл зорилгыг бүгдийг биелүүлж Бүх хаадын Хаан, бүх эздийн Эзэн, болсон тул бид ч Бурханы хүслийг бүгдийг нь биелүүлэх хэрэгтэй билээ.

Бидэн рүү хандсан Бурханы хүсэл нь ариун байдлыг төгс олж, мөн төгс итгэмжтэй байдал билээ. Ариун Сүнсний 9-н үр жимс, сүнс зүгийн хайр, 8-н ерөөлийг биелүүлэн «Дэлхий хязгаар хүртэл Намайг гэрчлэх болно» гэж айлдсанчлан хүмүүсийг аврах ажилд идэвхитэй оролцох хэрэгтэй билээ. Түүнчлэн хичээн зүтгэсээр ариун бэрийн бэлтгэлээ дуусгаад өөрийн үүргээ ч төгс гүйцэтгээд дахин ирэх Эзэнийг угтах үед бид «Гүйцэлдлээ!» хэмээн гэрчилж чадах ёстой байх хэрэгтэй.

Хайрт ах эгч дүү нар минь, Есүсийн загалмайн дээр айлдсан эцсийн долоон үгийг өөрсдийн сэтгэл зүрхэндээ гүн шингээж, Бурханы өмнө зөвт зохистой амьдралаар амьдран эцэстээ тэнгэрийн оронд ч хамгийн алдар сүр жавхлантай газарт мөнхөд Эзэнтэй хамт байхыг Их Эзэний нэрээр хүсэн ерөөе!

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
<http://www.manmin.org/english>
e-mail: manminministry@hotmail.com

Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин

«Бурханы хайр ба эрх мэдэлт хүчийг мэдэрч байгаад миний зүрх сэтгэл аз жаргалаар бялхаж бялхаж байна»

Ким Мёонсун Сүмд үйлчилэгч(61 настай, Чүнчон Манмин Сүм)

Сүүлийн үед миний амьдрал аз жаргалаар бялхаж байгаа нь Бурханы надад хайрласан хайр ивээл хүч юм. Үнэн хэрэгтээ, би дунд сургуулийн 2-р ангид (8-р ангид) тэнгэрийн харь хэлний ивээлийг авч, номлолын сургуулийг төгссөн боловч удаан хугацаанд сүмд олон яваагүй билээ.

Одоо би жинхэнэ итгэлийг Доктор И Жей руг пасторын сургаалын бичлэг, кассетуудаас номнууд ба Манмин мэдээ сониноос олж авсан билээ. Цаг нь болоход тэдгээрийг Сөүлд амьдардаг манай бэр эгч болох Парк Хэй жа Сүмд үйлчилэгч над руу үе үе илгээдэг байв. Нэгэн өдөр, санаандгүй байдлаар би Чүнчон Манмин Сүмийн Ким Дун хон пастортай машин засварын газар уулзсанаас хойш Бурханы хайр болон Эзний хайрыг илүү ихээр ухаарах болсон.

Эзнийг дуурайн амьдрах итгэлийн амьдрал

2010 онд би Чүнчон Манмин Сүмд очин сургаалиар дамжуулан итгэлийн амьдралын чухал зорилго нь Эзний зүрх сэтгэлийг явдал юм гэдгийг би ойлгосон юм.

Би өнөөг амьдармагцаа бусдад хохирол хүндрэл учруулж байсан удаагүй бөгөөд харин ч бусдад тусалж, үйлчлэн цайлган цагахан амьдарч ирсэн гэж боддог байлаа. Мэдээж гэм нүгэл бол надад огт



Бурханы хайраар насаа мартан амьдарч буй Ким Мёонсун сүмд үйлчилэгч (баруун гар талаас)

хамааралгүй гэж бодож байсан юм. Гэвч сургаалыг сонсож байхдаа, миний дотор буй худал хуурмагийн сэтгэл, бардам зан, өөрийнхөөрөө зүтгэдэг, эгдүүцэн дургүйлэхдэг зэрэг атгаг байдлууд илэрч гэмшлийн нулимс урсгаж байлаа.

Тэгж байтал Бурханы халуун хайрыг мэдэрсэн үйл явдал болсон юм. 2011 оны 4-р сард үсчиний газар ажилуулдаг би 3-н долоо хоногын турш би зүүн гар хүчтэй өвдөж байсан тул юу ч хийж чадахгүй байлаа. Бүр сүүлдээ хоолоо ч хийж чадахгүй байсан тул миний нөхөр надад тусладаг байв.

Тэгтэл Чүнчон Манмин сүмийн итгэгчид Доктор И Жей руг тэргүүн пастортай уулзах боломж гарав. Тэгээд би түүнээс залбирал

хүртсэн юм. Тэр өдрийн маргааш нь Эзний өдрийн мөргөл дуусгаад гэртээ ирж, агшаасан будааны хусам идэж байтал гэнэт хамрын угаас авахуулан сэнгэнэсэн гааны амт мэдрэгдэж эхлэв.

«Өө Энэ сэнгэнэсэн гааны амт үнэр хаанаас гарч ирэв ээ?» гэж би дотроо бодон гайхаж байлаа. Яг тэр мөчид, миний зүүн гарын бугуйнаас эхлэн хоёр өтгөн цагаан гэрэл гарч ирэн цацарч байснаа миний зүүн гарын үзүүрээс эхлэн манан шиг гаран замхарч байхыг хараад би яахаа мэдэхгүй маш их гайхаж байлаа. Энэ явдлаас өмнө зүүн гараа хөдөлгөж, юу ч хийж чадахгүй байсан боловч одоо маш чөлөөтэй урьдын адил хөдөлж байлаа.

Энэ үеэс хойш миний амьдрал Бурханы ивээлээр улам дүүрч байлаа. 6-р сард, миний зүүн гарын хуруун дээрх эвэр арилж, 7-р сард, би хэсэг, багийн удирдагч нарын сургалтанд сууж байхдаа гар утсаараа Бурханы угийн гэрэл «Урура гэрэл»-н зураг дарж, 8-р сард, Эрэгтэй эмэгтэйчүүдийн нэгдсэн зуны цуглааны үед үй олон тооны сононууд тэнгэрээс бууж ирэхийг харж миний бие нь дээр суухыг үзээд зэрэг үнэхээр гайхамшигтай зүйлүүд тохиолдож би их аз жаргалтай байсан юм.

Арвин Сайн мэдээний үр жимс

Би үзэж туулсан Бурханы гайхамшигт хүчийг ойр орчмын

хүмүүстэй гэрчлэн ярьж өгч, өнгөрсөн жилд би 10 хүнийг номлон авчирсан билээ. Тэд бүгд санал нэгтгэйгээр «Энэ сүд ирснээр итгэгч нь миний гэр бүл мэт санагдлаа.» гэлцэн аз жаргалтай байлаа.

Ялангуяа Пэ Су ёон итгэгч Доктор И Жей руг пасторын гэрчлэл ном болох «Үхлийн өмнө мөнх амийг амссан нь» номыг бүтэн нэг өдөр уншиж дуусгаад маш их ивээл хүртлээ гэж гэрчилж байсан юм. Түүний дараа бүлгийн мөргөлөөр манай хариуцагч пасторт Доктор И Жей руг пасторын залбирал хийж өгсөн эрх мэдэлт хүчит гарын алчуур (Үйлс 19:11-12)-аар залбирал авсан юм. Энэ итгэгч маань хэвлийн доод хэсгээр халуу оргихыг мэдэрсэн бөгөөд 14 жилийн турш өвдөж байсан ивэрхий буюу өндгөвчний хавангийн мэс заслын дараах үрэвсэлээс цэвэрхэн эдгэж, мөн шулуун гэдэсний үрэвсэлээс хүртэл эдгэрсэн юм.

Би өнгөрсөн жилийн сүүлээр би шилдэг хэсгийн ахлагчын шагнал хүртэж, энэ жил бүүр бүлгийн ахлагчаар сонгогдсон билээ. Юуны түрүүнд Эзнийг дуурайж илүү сайхан тэнгэрийн орон руу чиглэн давшиж, (Матай 11:12) байгаа тул баяр хөөр талархал дүүрэн байна. Мөн миний уулзсан хайрын Бурханыг илүү олон хүмүүст мэдүүлэхийн төлөө залбирч байна.

Жон Баби итгэгч (34 настай, Энэтхэг, Сайн мэдээний Сүм)

«Сүүлийн үед эхнэр бид 2 үнэхээр аз жаргалтай байна. Энэ нь 8 жилийн турш хүүхэдтэй болж чадахгүй байсан боловч залбирал аваад хөөрхөн гүнж Эрүши минь төрсөн учраас юм.»



Би одоогоос 4 жилийн өмнөөс Чэннай Манмин Сүм (Хан Жон хи хариуцагч пастор)-д цахилгааны, усны хоолойн гэх мэт ажлуудад тусалдаг байлаа. Тэнд ажиллаж байхдаа гайхамшигтай үйл явдлын тухай гэрчилж байгаа сүмийн гишүүдийг сонссон.

Ялангуяа миний анхаарлыг ихэд татсан зүйл нь 2008 оны 11-р сард И Ми геон пасторын удирдсан «Гар алчуур»-н цуглаанд оролцон үр хүүхэд олох ивээл хүртсэн Росилин ба Мула хоёрын гэрчлэл надад урам өгсөн юм.

Бид 2004 оны 2-р сард гэрлэсэн боловч

тэр хүртэл хүүхэдгүй байлаа. Мөн түүнчлэн, Бурханы хүчит боол Доктор И Жей руг пасторын залбирлаар дамжуулан үр хүүхэдгүй олон гэр бүл хүүхэдтэй болсон тухай гэрчлэл маш их байдгийг олж мэдсэн юм.

Энэ нь надад их итгэл найдвар төрүүлэв. «Бидэнд ч гэсэн Бурхан хүүхэд өгөх болно» гэж итгэлээрээ хэлэн залбирч байлаа. Би сүмд ажиллаж байхдаа хувьдаа илүү их ашиг эрэлхийлээгүй бөгөөд их цалин өгөхийг гуйгаагүй ба зөвхөн өөрийн зүрх сэтгэлээрээ итгэмжтэйгээр ажиллаж байлаа.

2010 он гарахад би сая л нэг юм сайхан мэдээ сонслоо. Тэр нь Манмин Залбирлын төвийн дарга Хатагтай И Бокним 12-р сард Чэннай Манмин сүм гар алчуурийн цуглаан болно гэсэн мэдээ юм. Хэдийгээр өөр сүмд явдаг ч сэтгэл зүрхээр бэлдэн гэр бүл болон таньдаг хүмүүсээ урин тэр цуглаанд оролцсон юм.

Эцэст нь, бид Хатагтай И Бокнимын залбирлыг авсны дараа 2011-2-14-нд эмнэлэгт шинжилгээ хийлгэтэл хүүхэдтэй болсон гэх хариу гарсан юм. Миний эхнэр 11-р сарын 23-нд 3,1кг жинтэй эрүүл саруул охин төрүүлсэн юм. Халлелуяа!

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:

Г. Анхбаяр СМТ 976-91173712

976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com



Бурхан бол Агуу Их Эдгээгч юм!

ДэнВүүдин сэтгүүлч
(АССИСТ Мэдээлэлийн Албаныүүсгэн байгуулагч болон АССИСТ-н олон улсын захирал)

1960 оны нэгэн өдөр би ээжээсээ захидал хүлээн авсан. Энэ нь миний аавын эрүүл мэндийн тухай ноцтой мэдээ байв. Ээж хэлэхдээ: «Аав чинь нарийн гэдэсний хавдрын сүүлчийн үе шатанд орсон байна. Түүнд гурван сар л амьдрах хугацаа үлдсэн байна!» гэв.

Тэр үед би Канадад байсан боловч ээжтэйгээ байхын тулд Их Британи руу буцаж очсон юм. Би аавынхаа төлөө ээжтэйгээ болон эмэгтэй дүүтэйгээ хамт чин сэтгэлээсээ залбирч байлаа. Бурхан бидний залбирлыг сонсон хариулан өгч аав маань гайхалтайгаар эдгэрэн түүнээс хойш 30 гаруй жил амьдарсан билээ. Энэ үйл явдал намайг Есүсийг Аврагчаар хүлээн зөвшөөрөхөд хүргэсэн юм. Гэвч би Их Британид сэтгүүлчээр ажиллаж байхдаа Бурханаас дахин хөндийрсэн юм.

Нэгэн өдөр найз маань надад ингэж хэлсэн юм «Дэн, Бурхан чамд сайн сэтгүүлч байх авьяас билгийг заяасан боловч чи чанар муутай өгүүлэлүүдийг бичих юмаа. Би чамайг Угандад сайн мэдээ тарааж буй христчин хүмүүсийн тухай, тэдний яаж хавчигдаж, байгаа тухай бичвэл ямар вэ?» гэсэн юм.

Би Христын хэвлэлмэдээлэлийн алба Ассистыгүүсгэн байгуулсан

1979 онд би Угандад очиж тэнд Христчин хүмүүсүүдийг яаж хавчиг байгаа тухай бодит байдлыг мэдээлэхийн тулд энэ талаар ажиллаж эхлэв. Мөн би 1992 онд Билли Грахам пасторын Москва дахь их цуглаантай холбогдолтой нийтлэл бичиж тухай үедээ чадварлаг сэтгүүлч гэж хүлээн зөвшөөрөгдөж байлаа.

Би тэр цуглаанаас буцаж ирэхэд эхнэр маань надад «Билли Грахам пастор хүртэл Бурхан таньд ийм авьяас чадварыг өгч байхад яагаад энэ талаар үргэлжлүүлэн бичиж болохгүй гэж» асууж байгаа тухай хэлсэн юм.

Үнэндээ, би сэтгүүлчийн ажлаа

өөрийн төөрөлдсөн амьдралдаа харамсан Москва дахь их цуглаан хүртэл түр зогсоосон байсан юм. Гэсэн ч эхнэрийнхээ зөвлөсний дагуу «Өөрийн авьяас чадвараа Бурханы төлөө зориулыя» хэмээн сэтгэлдээ шийдэж, энэ нь намайг «Ассист мэдээлэлийн алба»-г үүсгэхэд хүргэсэн билээ (www.assistnews.net).

Ассист Мэдээлэлийн Алба бол дэлхий даяарх сайн мэдээ тараах үйлс, хавчигдаж буй сүм цуглаануудын төлөө АР болон Ройтэр шиг хэвлэл мэдээллийн алба юм. Бид дэлхийн даяарх 2600 орчим хэвлэл мэдээллийн ажилтан сэтгүүлчдэд болон олон мянган хэвлэл захиалагчдад зориулж мэдээ мэдээлэлээр хангадаг юм.

Би нэр хүндтэй хүмүүсээс, жишээ нь «Хатан Хаан Элизабет II» болон нэртэй байгууллагуудаас олон шагнал хүртсэн. Би одоо олон улсын нэгдсэн хэвлэлийн агентлагт (UPI)-д тайлбарлагчаар ажиллаж ярилцлагад орон маш завгүй байдаг. Эдгээрийн дундаас хамгийн утга учир бүхий маш чухал уулзалт нь Манмин төв сүмийн тэргүүн пастор Доктор И Жей руг пастортай уулзсан явдал байлаа.

Доктор И Жей руг пасторын гадаад дахь нэгдсэн их цуглаануудын тухай мэдээлэл

Би 2001 онд Киприйн Бүгд Найрамдах улсад чуулсан SAT 7 (Арабын Христийн Телевизийн Нэвтрүүлэг)-т чуулганы үеэр Ким Жин ху ахлагчтай (GCN Телевизийн дэд захирал) уулзан анх удаа Манмин төв сүмийн тухай мэдэж авсан. Түүнээс хойш Доктор И Жей руг пасторын удирдсан Орос, Герман, Перу, АНУ болон Израйль зэрэг улсад болсон нэгдсэн их цуглааны талаар мэдээлж эхэлсэн билээ.

Жишээлбэл, сайн мэдээ тараахад тэр хэмжээгээр хаалттай улс орнуудад том хэмжээний цуглаануудыг бий болгосонд

байгаа юм. 2002 оны Энэтхэгийн нэгдсэн их цуглаан нь Энэтхэгийн Чэннай хотын Марина далайн эрэг хавийн болоход Энэтхэгийн засгийн газар болон Тамил Наду сөрөг хүчнийхэн цуглааны үйл ажиллагааг хорьж, тараахыг оролдсон боловч тэр цуглаанд гурван сая гаруй хүн цугларсан бөгөөд маш олон хүмүүс Эзнийг хүлээн авсан юм.

Тухайн үед яг Есүсийн шавь нар маш их хавчлага дотор сайн мэдээ тарааж тэдний айлдсан үг сургаалийг нь дагалдах тэмдэг гайхамшигуудаар хамт байсан шиг сайн мэдээг хорьж эсэргүүцдэг улсад ч огтхон ч айх зүйлгүй гайхамшигтай тэмдэг болон эрх хүчит үйлсээр Есүс Христийг баттайгаар тунхаглаж байгаа Манминий үйл ажиллагаа үнэхээр бахархмаар явдал билээ.

Мөн түүнчлэн Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбоо(WCDN)-үйл ажиллагаа миний сонирхлыг татаж байгаа билээ. Би мөн (WCDN)-ы олон оронд зохион явагдсан эмч нарын чуулга уулзалтуудын талаар нийтлэл бичлээ. Дэлхийн өнцөг бүрээс цугларсан олон эмч нар Бурханы хүч чадлаар эдгэрсэн тухай материалуудыг анагаах ухааны зүгээс эмнэлгийн дүгнэлт гарган танилцуулдаг нь гүн утга ба ач холбогдол бүхий ажил билээ. Энэ нь үл итгэгч хүмүүст библи бол үнэн болохыг нотолж буй хэрэг юм.

Миний сонирхлыг ихэд татсан Манмин Төв сүмийн хүчит үйлсүүд

Би одоо долоон удаа Манмин Төв сүмд зочилсон билээ. Тэр болгонд сүмийн итгэгчиднь Доктор И Жей руг пастор таа хичнээн хайртай болохыг мөн Доктор И Жей руг пастор ч итгэгч нартаа ямар онцгой хайраар хайрладаг болохыг гүн харьцаатай байдгийг мэдэрсэн билээ. Ингэж хоньчин ба итгэгчдийн хооронд сүнс зүгийн хайрын харилцаа байгааг сүмийн хаанаас ч мэдэх

боломжтой билээ.

Мөн Түүний сургаалууд нь сүнс зүгийн хүчтэй бөгөөд үзэсгэлэнтэй сайхан магтаал дууны тоглолтууд, Эзэнд үйлчилж буй магтаал дуу бүжгийн багууд нь тэнгэрийн орны сайхныг дүрсэлдэг юм.

Би Доктор И Жей руг пасторын залбирал ба сургаалиар тунхаглагдсан Бурханы хүчийг баттайгаар гэрчилж байгаа билээ. Өвчин зовлон дотор амьдарч буй хүмүүст итгэлээрээ Бурханы ивээл ба хүчийг мэдрэх боломжтойг харуулан гэрчилсээр байна.

Мөн түүнчлэн Дэлхийн христийн нэвтрүүлгийн сүлжээ(GCN)-ний нэвтрүүлэг ба хэвлэл нийтлэлийн үйл ажиллагаа, Мүан амтат ус, Гар алчуурын цуглаанууд зэргээр дамжуулан Солонгосын орон нутаг төдийгүй дэлхий өнцөг булан бүрт асар олон хүмүүс Есүс Христийг хүлээн авч буй гайхамшигт үйлсүүд тасралтгүй үргэжилсээр байгаа билээ. Энэ гайхамшигт Манминий хүчит үйлсүүдтэй холбогдолтой мэдээнүүдийг би дэлхий даяар тараах үйлсэд хүчин зүтгэж байгаа юм. Ялангуяа хойд Солонгос дахь сайн мэдээ тараах ажил болон WCDN-ий (Дэлхийн Христэд итгэгч эмч нарын холбоо) цаашдын ажилд анхаарлаа хандуулж байна.

Духан дээр бий болсон арьсны хорт хавдараас эдгэрсэн нь

2011 оны 10-р сарын эхээр би гайхамшигт зүйлийг мэдэрсэн юм. Нэгэн өдөр миний духан дээр арьсны үрэвсэл үүсч бага

багаар томорч байлаа. Арьсны дээжний шинжилгээ хийлгэхэд намайг арьсны хорт хавдартай гэж оношилж энэ хавдарыг мэс засал хийж байж төгс эдгэрэх боломжтой гэсэн юм.

10-р сарын 7-нд би Манмин Төв Сүмийн 29-н жилийн ойн баярын өмнөх баасан гаригийн мөргөлд оролцож сургаал дуусах үед Доктор И Жей руг пастор «Өвчин эдгээх залбирал» индэр дээрээс нийтэд нь хийсэн юм. Тэр үед би духан дээрээ гараа тавьж итгэлээрээ залбирал авсан юм.

Яг тэр мөчид, миний духанд цахилгаан гүйдэл цохих шиг ямар нэг юм ороод явчих шиг санагдав. Тэр мөчид би эдгэрсэн гэдэгтээ бүрэн итгэх итгэл орж ирсэн юм.

Би Америкд эргэж ирээд эмчтэйгээ уулзаж өрт тохиолдсон явдлаа хэлэн дахин шинжилгээ хийлгэв. Миний итгэсэнчлэн надад ямар ч хорт хавдрын эс байхгүй төгс эдгэрсэн байлаа. Би үүнийг сонсоод маш их баярлаж сэтгэл догдлосондоо эхнэр Нормагаа тэвэрч авав. Энэ бүх зүйл Доктор И Жей руг пасторын залбиралд хариулж өгсөн Бурханы гайхалтай хүчит үйлс байсан юм.

Бурхан бол агуу их Эдгээгч Эзэн билээ. Бурханы агуу их хүч чадал өчигдөр ч өнөөдөр ч хэвээрээ гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна. Хэрвээ та бүхний дунд өвчнөөсөө болж шаналж зовж байгаа хүн байвал Бурхан та нарт ч Өөрийн хүчит үйлсээ үзүүлдэсэй хэмээн залбирч байна. Тиймээ, та Бурханы хүч чадалд бүх найдвар тавихыг хүсье!



Хайрт гэргий Нормагийн хамт

Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.manmintv.org